Money Market Fund

Арилждаг хадгаламж

# Харилцагчийн гарын авлага.

## 1. Нэвтрэх

www.moneymarket.mn вэб хаягт хандаж нэвтрэх командыг сонгоно. Бүртгэлтэй и-мэйл хаягт илгээгдсэн нэвтрэх нэр, нууц үгийг харгалзах талбарт оруулж платформд нэвтэрнэ.




Нууц үгийг оруулахдаа илүү тэмдэгт, хоосон зай авсан эсэхийг шалгаарай.

Шинээр нэвтэрч орсон тохиолдолд нууц үгийг заавал солих шаардлагатайг анхаарна уу.

Нууц үг нь том жижиг үсэг, тусгай тэмдэгт, тооноос бүрдсэн 8-аас доошгүй оронтой байна.

## 2. Хэтэвч цэнэглэх

Хэтэвч цэсээр орж орлого командыг сонгоно.







Өөрийн интернет банк эсвэл мобайл аппликейшнаар холбогдох Мони Маркет Фанд ХХК-ийн харилцах дансанд гүйлгээний утгыг хуулан шилжүүлнэ. Хэтэвчийг цэнэглэсэн даруйд хэтэвч цэсэнд үлдэгдэл дүн харагдана.



## 3. Анхдагч арилжаанд оролцох

Арилжаа цэсний анхдагч хэсэгт анхдагч арилжаанаас авах боломжтой бүтээгдэхүүнүүд байна.







АВАХ коммандыг сонгон худалдан авах ширхэгийг оруулснаар тухайн худалдан авах бүтээгдэхүүний дэлгэрэнгүй тооцоолол гарна.

Нэвтрэх нууц үгээ дахин оруулан баталгаажуулж худалдан авах товчийг дарснаар анхдагч арилжаа хийгдэнэ.

Анхдагч арилжаа зөвхөн ажлын өдрийн 09:00 - 15:30 цагийн хооронд явагдах болохыг анхаарна уу.

Арилжаа цэсний зарах захиалгуудаас өөрт тохирох хугацаа, хүү, үнэтэй бүтээгдэхүүнүүдээс хоёрдогч арилжаагаар сонгон авах боломжтой (хуудас 3-ыг үзнэ үү).




Бүртгүүлсэн и-мэйл хаягаар Хадгаламжийн сертификатын гэрээ илгээгдэнэ.

Худалдан авсан бүтээгдэхүүн Миний самбар цэсэнд дараах байдлаар харагдана.




Мөн хэтэвч цэсний данс хэсэгт худалдан авсан бүтээгдэхүүнүүд жагсаалт байдлаар харагдана.

## 4. Хоёрдогч арилжаанаас худалдан авах

Арилжаа цэсний баруун талд байрлах авах хэсэгт хоёрдогч арилжаанд зарагдах боломжтой бүтээгдэхүүнүүдийн жагсаалт байна.




Худалдан авах бүтээгдэхүүнээ сонгон худалдан авах үнийн саналаа мөнгөн дүнгээр, эсхүл хувиар илэрхийлэн авах коммандыг сонгон санал оруулна.




| |
|---|
| *Бүтээгдэхүүний Симболыг дараах утгаар ойлгоно. Жишээ нь: CAPIT 1100 CD 041223* |
| *CAPIT – Хадгаламжийн сертификат гаргасан Банкны товчилсон нэр* |
| *1100 – Жилийн 11.00% хувийн хүү* |
| *CD – Certificate of Deposit буюу Хадгаламжийн сертификат* |
| *041223 – төлөгдөх огноо буюу 2023 оны 12 сарын 04-ний өдөр* |




Хоёрдогч арилжаанаас худалдан авах санал оруулахад дараах байдлаар дэлгэрэнгүй тооцоолол харагдана.

Худалдан авах товчийг дарснаар худалдан авах захиалга бүртгэгдэнэ.

(Таны оруулсан санал тухайн бүтээгдэхүүнийг эзэмшиж буй бүх эзэмшигчдэд и-мэйлээр хүргэгдэнэ.)

Тухайн бүтээгдэхүүний эзэмшигч нь таны саналыг зөвшөөрснөөр арилжаа амжилттай биелнэ.

Жич: Худалдан авах санал оруулах үед таны бэлэн мөнгөний дансанд хангалттай хэмжээний эх үүсвэр байхыг анхаарна уу.

## 5. Хоёрдогч арилжаанаас шууд худалдан авах

Хоёрдогч зах дээр бүтээгдэхүүнээ худалдах бусад харилцагчийн саналуудаас сонгон шууд арилжааг гүйцэтгэх боломжтой.



Ингэхдээ төрөл багана дахь зарах саналуудаас сонгон авах товчийг дарна.




Худалдан авах ширхэгийг оруулснаар дэлгэрэнгүй тооцоолол гарна.

Нэвтрэх нууц үгээ дахин оруулж баталгаажуулан худалдан авах товчийг дарснаар хоёрдогч арилжаа хийгдэнэ.

Жич: Худалдан авах санал оруулах үед таны бэлэн мөнгөний дансанд хангалттай хэмжээний эх үүсвэр байхыг анхаарна уу.

## 6. Хадгаламжийн сертификат худалдах

Арилжаа цэсний баруун талд байрлах зарах хэсэгт таны худалдах боломжтой, эзэмшиж буй бүтээгдэхүүнүүдийн жагсаалт байна.



*Худалдах нөхцөл:*

*Тухайн өдөр дуустал хүчинтэй – Таны оруулсан санал тухайн өдөртөө хүчинтэй.*

*Заасан өдөр хүртэл хүчинтэй – Заасан өдөр хүртэл таны оруулсан санал хүчинтэй.*

*Нөхцөл биелтэл хүчинтэй – Таны оруулсан саналыг өөр этгээд сонгон биелүүлэх хүртэл хүчинтэй*




Худалдах бүтээгдэхүүнээ сонгон ширхэг, үнэ, нөхцөлийг оруулан худалдах товчийг дарахад дэлгэрэнгүй тооцоолол гарна.

Тооцооллыг шалгаж худалдах товчийг дарснаар таны санал бүртгэгдэнэ.

Таны саналыг худалдан авагч зөвшөөрч биелүүлснээр арилжаа амжилттай хийгдэнэ.

## 7. Хадгаламжийн сертификат шууд худалдах

Хоёрдогч арилжаагаар бусад харилцагчийн худалдан авах саналуудаас сонгон шууд арилжааг гүйцэтгэх боломжтой.



Арилжаа хэсэгт таны эзэмшиж буй бүтээгдэхүүнийг худалдан авах саналуудаас сонгон зарах товчийг дарна.




Худалдах ширхэгийг оруулснаар хоёрдогч арилжаагаар худалдах дэлгэрэнгүй тооцоолол гарна.

Тооцооллыг шалгаж худалдах товчийг дарснаар таны санал бүртгэгдэнэ.

Таны саналыг худалдан авагч зөвшөөрч биелүүлснээр арилжаа амжилттай хийгдэнэ.

## 8. Хэтэвчээс зарлага гаргах

Хэтэвч цэснээс зарлага товчийг дарна.







Зарлага хийх мөнгөн дүн, гүйлгээний утгаа оруулан гүйлгээ хийх товчийг дарснаар хэтэвчнээс хасагдана.

Зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулсны дараа таны бүртгэлтэй банкны дансанд шилжинэ.

Таны 15:30 цагаас хойш хийгдсэн зарлагын гүйлгээ дараагийн ажлын өдөр шилжин орохыг анхаарна уу.



Мөнгөн гүйлгээ болон бүтээгдэхүүний хуулга хэтэвч цэсний хэтэвч хэсэгт харагдана.



Хэтэвч цэсний данс хэсэгт одоо эзэмшиж байгаа бүтээгдэхүүн болон өмнөх захиалгууд жагсаалтаар тус тус харагдана.

Утас: +976 7018-7700
Мэйл: contact@moneymarket.mn
Веб: moneymarket.mn

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, 1 хороо, Бага тойруу, ЖЖ цамхаг, 10 давхар